

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар А/414

Улаанбаатархот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг энэхүү тушаалаар батлагдсан журмыг баримтлан сонгон шалгаруулж, томилохыг эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.
- 3.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулахад шаардагдах зардлыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг эмнэлгийн захирал нарт үүрэг болгосугай.
- 4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д даалгасугай.
- 5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/454, 2020 оны А/566, 2021 оны А/127 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.ЭНХБОЛД